



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/155

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлөөр олгосон эрх хасах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 01/76 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Ахметын Ерболдод ИЭ0025143 сери, 0025143 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар хассугай.

2. А.Ерболдод эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг хассантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг гурван сарын хугацаагаар хассан тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр олгосон эрхийг хассан талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /М.Цэрэнбат/, Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Мөнхцэцэг/, Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар /С.Айгүл/, Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Мухамед/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

• 141210763